



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 28 өдөр

Дугаар А/196

Булган сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIV хуралдааны "Булган аймгийн 2023 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай" 14/01, мөн 2020 оны II/04 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны А/112 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн "Хүндэт иргэний шагнал, медаль"-ийн загвар шалгаруулах уралдаанд тэргүүн байр эзэлсэн оролцогчийг шагнасугай.

2.Тус уралдаанд тэргүүн байр эзэлсэн З.Жамбалсүрэнд шагналын мөнгө болох 2,000,000 (хоёр сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Д.Алтаншагай)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ